



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/262

Улаанбаатар хот

Хуулийн хэрэгжилтийг хангах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2021 оны ХЭГ/893 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2021-2024 онд боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах хуулийн жагсаалтыг нэгдүгээр, Засгийн газраар батлуулах журам, дүрэм, зааврын жагсаалтыг хоёрдугаар, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах шийдвэрийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтад заасан дүрэм, журмыг хугацаанд нь шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулахыг хариуцсан газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын Захиргаа, хуулийн хэлтсийн дарга /Л.Дашравдан/-д даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141211277

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн А/262 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2021-2024 онд боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах хуулийн жагсаалт

Д/д	Хуулийн нэр	Хариуцах газар	Өргөн мэдүүлэх хугацаа	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үндэслэл, зохицуулах харилцааны товч утга
1	Эх, хүүхдийн эрүүл мэндийн тухай	Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар	2021	Эх, хүүхдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхийг хангахад төр, аж ахуйн нэгж, байгууллага, гэр бүл, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах. тархины үхэлтэй донортой холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгаж, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэх ёс зүйн хороог Эрүүл мэндийн яамны дэргэд байгуулах асуудлыг хуульчлах. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны санхүүжилтийн тогтолцоог шинэчлэхийн тулд гүйцэтгэлээр санхүүжүүлэх, донор эмнэлэг, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож байгаа ажилтныг урамшуулах, донор, реципиент, гэр бүлд дэмжлэг үзүүлэх нийгмийн хамгаалал, халамжийн асуудлыг цогцоор шийдэх, эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв байгуулах.
2	Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар	2021	
3	Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай	Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар	2022	
4	Цусны донорын тухай	Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар	2022	Цус сэлбэлт судлалын салбарт ажилладаг эрүүл мэндийн ажилтныг урамшуулах, цусны байнгын донорт дэмжлэг үзүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, халамжийн асуудлыг сайжруулах, цус өгсөн донорыг халуун хоолоор үйлчлэх, хүн амын дунд цусны донорын сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх, цусны донорын үйл ажиллагааг дэмжин хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг урамшуулах, цусны донорын үйл ажиллагааг дэмжин зарцуулсан зардлыг нь татвараас чөлөөлөх зэрэг цусны нөөц, хангамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчныг

				<p>бий болгох, үндэсний аюулгүй байдалтай холбоотой онцлог салбарын хувьд төрөөс цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн талаар баримтлах бодлогын баримт бичигтэй болгох, түүнчлэн цусны донорын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн аюулгүй байдал, нууцлал, бэлэн байдал, цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж, хүртээмж, чанар, цаашид бүрдсэн нөөцийг ашиглан эмчилгээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж, санхүүжилтийг цогцоор шийдвэрлэх.</p>
5	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай	Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар	2022	<p>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэсэн хоёр төрөлтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохицуулалтыг 2016 оноос эхлэн бие даасан Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар зохицуулах болсон тул энэ хуулиар нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр болон бусад олон харилцааны тодорхойгүй байгаа эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.</p>
6	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар Төрийн захиргааны удирдлагын газар	2022	<p>Эрүүл мэндийн тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, эмгэг судлалын амьд ахуйн эд эсийн шинжилгээ, нас барагчийн цогцсыг сургалт, судалгааны зорилгоор ашиглах зохицуулалтыг шинээр тусгах, магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хөндлөнгийн, хараат бус, бие даасан байдлаар хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх, түүнчлэн анагаах ухаанаас бусад салбар шинжлэх ухааны мэргэжил эзэмшсэн эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа ажилтны нийгмийн асуудлыг зохицуулах.</p>
7	Хүний генетикийн тухай	Төрийн захиргааны удирдлагын газар	2023	<p>Монгол хүний генетикийн банктэй болох эрх зүйн орчныг бүрдүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх оношилгоо, эмчилгээнд дэвшилтэт технологи, арга, заавар, стандарт нэвтрүүлэх, шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн болон хүний аюулгүй байдлыг хамгаалах зохицуулалтыг хуульчлах.</p>

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 19 ны өдрийн 4/462 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Засгийн газраар батлуулах журам, дүрмийн жагсаалт

Д/д	Хуулийн нэр	Хуулийн заалт	Хариуцах газар	Хугацаа
1	Эрүүл мэндийн тухай хууль	8.4. Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ажиглах журмыг Засгийн газар батлана.	Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар	2021 оны 2 дугаар улирал
2	Донорын тухай хууль	20 дугаар зүйл. 20.3. Донорын цус, цусан бүтээгдэхүүн, сорьц, эд, эрхтний улсын хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батлана.	Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар	2021 оны 2 дугаар улирал
3	Хүний дархлал, хомсдолын халдвар, дархлалын хомсдолоос сэргийлэх тухай	4 дүгээр зүйл. 4.1. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохицуулан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хороо ажиллуулах;	Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар	2021 оны 2 дугаар улирал

4	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай	4.1.4-энэ хуулийн 4.1.3-г заасан Үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрмийг батлах.	21 дүгээр зүйл. 26.1.Хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, клиник, түргэн тусламжийн төвөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх энэ хуулийн 18.1-д заасан улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сонгон шалгаруулах болон гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг Засгийн газар батална.	Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар	2021 оны 2 дугаар улирал
---	---------------------------------------	--	---	--	--------------------------

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 10 ны өдрийн А/162... дугаар тушаалын гуравдугаар хавсралт

1. Эрүүл мэндийн даатгалын тухай болон Эрүүл мэндийн тухай хуулийг дагаж шинээр болон шинэчлэн батлах шийдвэрийн жагсаалт

д/д	Эрх олгосон хууль, тогтоомжийн нэр, зүйл заалт	Журмын нэр	Журам, дүрмээр зохицуулах харилцааны агуулга	Хариуцах газар	Хугацаа
1	Эрүүл мэндийн тухай хууль, 29 дүгээр зүйл, 29.5 дэх хэсэг	Мөнгөн тэтгэмж олгох журам /шинээр батлах/	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын, аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгоно.	Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар	2021 оны 2-3 дугаар улирал
2	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7 дахь заалт	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журам /шинээр батлах/	Даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах.	Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар	2021 оны 2-3 дугаар улирал

3	ЭМД-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.12 дахь заалт	Орон тооны бус техникийн хороо ажиллуулах журам /шинээр батлах/	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хороог тухайн асуудлаар мэргэшсэн шинжээч, судлаач, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, даатгуулагчийн оролцоотой байгуулж, ажиллах журмыг батлах, холбогдох шийдвэрийг техникийн хорооны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн гаргах.	Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар	2021 оны 2-3 дугаар улирал
4	Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дэх заалт	Анхан шатны тусамж үйлчилгээний төлбөрийн арга, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх журмыг батлуулах /шинэчлэн батлах /	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ЭМД-аас санхүүжих 4 төрлийн тусламж, үйлчилгээний багцын хүрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, мөн улсын төсвөөс санхүүжүүлдэг тусламж үйлчилгээний аргачлалтай нэгтгэж анхан шатны тусламж үйлчилгээний төлбөрийн арга, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх журмыг батлуулах	Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар	2021 оны 2-3 дугаар улирал
5	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.11 дэх заалт	Сонгон шалгаруулалтын журам батлуулах /шинэчлэн батлах./	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах	Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар	2021 оны 2-3 дугаар улирал
6	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалт	Гэрээний загвар батлах, гэрээний биелэлтэнд хяналт тавих журам /шинэчлэн батлах /	Даатгуулагчийг төлөөлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай тусламж, үйлчилгээ худалдан авах даатгалын гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх."	Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар	2021 оны 2-3 дугаар улирал

7	Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.3 дэх заалтыг хэрэгжүүлэх.	Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг төрийн санд байршуулах, зарцуулах журам /шинээр батлах/	Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг төрийн санд байршуулах, зарцуулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах	Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар	2021 оны 2-3 дугаар улирал
8	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг	Бүтээмжийн урамшуулал олгох журам /шинээр батлах/	Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч, мэргэжилтэнд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт хангасан байдал, ажлын үр дүнг үндэслэн бүтээмжийн урамшуулал олгох харилцаа	Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар	2021 оны 2-3 дугаар улирал

2.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль,
"Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийг дагаж шинээр батлах журмын жагсаалт

д/д	Эрх олгосон хууль, тогтоомжийн нэр, зүйл заалт	Журмын нэр	Журам, дүрмээр зохицуулах харилцааны агуулга	Хариуцах газар	Хугацаа
1.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль"-ийн 10.2.5	Журам батлах тухай	"Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журам" боловсруулж, батлах Шадар сайд/Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлуулна	Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар	2021 оны 3 дугаар улирал
2.	"Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль"-ийн 15.3	Журам батлах тухай	Эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулах журмыг боловсруулж, батлах	Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар	2021 оны 3 дугаар улирал